

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГООС 3 ДАХИН ИХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ АВСАН НЬ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ
НИЙЦЭХГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “НИЙТИЙН АЖ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ДАА-2023/36-ШТА-ГА



Дархан-Уул аймаг
2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70378845 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

АГУУЛГА

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:	5
НЭГ. БҮТЦИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ БОГИНО ХУГАЦААНД ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ	6
А.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодитой, үнэн зөв тайлагнаагүй байна	6
А.1.1. Байгууллагын дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаагүй байна	6
А.1.2. Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн тайланг бодитой тайлагнаагүй байна	6
А.1.3. Аж ахуйн тооцоонд шилжих үйл ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагджээ	7
А.2. Байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт хангалтгүй байна	7
А.2.1. Байгууллагын дотоод хяналт хангалтгүй байна	7
А.2.2. Хөндлөнгийн хяналт шалгалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан байна	8
ХОЁР. ТӨЛӨВЛӨСӨН ОРЛОГО 16.3 ХУВИАР ТАСАРЧ, ЗАРДЛЫГ 192,505.0 МЯНГАН ТӨГРӨГӨӨР ХЭМНЭСЭН БАЙНА	9
Б.1. Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна	9
Б.1.1. Хог тээврийн үйлчилгээний хураамжийн хэмжээг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулсан боловч 2022 оны аж ахуйн нэгжийн хураамжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна	9
Б.1.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж тооцсон хугацаанд хэрэгжээгүйгээс орлогын төлөвлөгөө 16.3 хувиар тасарсан байна	10
Б.2. Тайлант онд дунджаар 50 орон тоо дутуугаас зардлыг 192,505.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна	10
Б.2.1. Үйл ажиллагааны зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна	10
Б.2.2. Байгууллагын анхан шатны баримтын бүрдэл хангалттай боловч хууль, журамд нийцээгүй 32,607.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна	11
ГУРАВ. ТУС БАЙГУУЛЛАГА ХӨРӨНГИЙГ БҮРЭН АШИГЛАЖ БАЙНА	13
В.1. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулаагүй байна	13
В.1.1. Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулсан байна	13
В.1.2. Тайлант хугацаанд 11,577.4 мянган төгрөгийн GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигч худалдан авснаар шатахууны зардлыг 3,429.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна	13
В.2. ОНХО, ОНХС-аар бий болсон хөрөнгүүдийг бүрэн ашиглаж байна	14
В.2.1. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь байгууллагын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна	14
В.2.2. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалт хангалттай сайн байна	15
В.2.3. “Хуванцар үрэл боловсруулах үйлдвэр” тэтгэлэгт оролцон, 45,000.0 мянган төгрөгийн 3 тоног төхөөрөмжийн санхүүжилт авсан боловч хэрэгжээгүй байна	16
Холбогдох байгууллагын санал, тайлбар:	17
ДҮГНЭЛТ:	18
ЗӨВЛӨМЖ:	19
Аудитаар тогтоосон төлбөрийн акт:	20
Аудитаар хүргүүлсэн албан шаардлага:	22

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГАУ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НААҮГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах ажил

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2022 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа	10

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Зардлын ангиллын эзлэх хэмжээ	10
Дүрслэл 2	Шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалт	13

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигч	13
Зураг 2	Хөрөнгө оруулалтаар бий болсон зарим хөрөнгүүд	14
Зураг 3	Дахин боловсруулах хог хаягдал хүлээн авах цэг	15

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/02 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв. Аудитын зорилт “Нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх • Орлогыг бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан эсэх • Хөрөнгө оруулалт болон хөрөнгийн ашиглалт үр дүнтэй эсэх Аудитын хамарсан хүрээ Аудитад “Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар” болон “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа. Аудитын бүрэлдэхүүн, хугацаа Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батцэцэг ахалж, аудитор Б.Алтанзул, Г.Батмягмар нар гүйцэтгэсэн. Хүндрэл бэрхшээл Аудитын явцад хүндрэл бэрхшээл гараагүй болно.
--	---

Аудитын тайлан батлагаажуулсан тушаал:



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 060

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалга, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн “Нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон 53/01-А0960281-ДАА-2023/36-ШТА-ГА, 54/02-А0970285-ДАА-2023/36-ШТА-ГА тоот албан шаардлагыг баталсугай.

3. Аудитаар тогтоосон 65/01-А0960281-ДАА-2023/36-ШТА-ГА, 66/02-А0960281-ДАА-2023/36-ШТА-ГА тоот төлбөрийн актыг баталсугай.

4. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга С.Насанбат, Засаг дарга Б.Азжаргал, Дархан сумын ИТХ-ын дарга Я.Бат-Очир, Засаг дарга Т.Тулгаа, “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат нарт хүргүүлсүгэй.

5. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбатад зөвлөсүгэй.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитад холбогдох нотлох баримтыг архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгч, албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг (ахлах аудитор С.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Батсүрэн)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



009010051

D:\Bichig hereg\Tushaal.docx

НЭГ. БҮТЦИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ БОГИНО ХУГАЦААНД ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ

А.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодитой, үнэн зөв тайлагнаагүй байна

А.1.1. Байгууллагын дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаагүй байна

1.1. Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймгийн “Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар”-ыг Дархан сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлжээ.

1.2. НААҮГ 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Дархан-Уул аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

1.3. Ингэхдээ Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчлээгүй, тус газарт хамааралтай 7 зорилтын 8 арга хэмжээ тусгагдсанаас 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын 3 арга хэмжээ тусгагдаагүй байна.

1.4. “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ыг 2025 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Дархан сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн Б/74 дугаар захирамжаар баталсан байна.

1.5. Уг стратеги төлөвлөгөөний дагуу айл өрх, албан байгууллагаас авах хог хаягдлын хураамжийг жил бүр тодорхой үе шаттайгаар нэмэх, бусад нэмэлт орлогоор зардлаа нөхөж, орон нутгийн төсвөөс дэмжлэг авахгүй байхаар тооцоолол гаргаж, батлуулжээ.

1.6. Ингэснээр тус газар аж ахуйн тооцоонд бүрэн шилжиж, Дархан хотын цэвэр цэмцгэр байдал, хотын ногоон байгууламж, өнгө үзэмж, тав тухыг нэмэгдүүлэх, хотын гэрэл, гэрэлтүүлгийн системийн найдвартай байдлыг ханган бие даан ажиллах боломж бүрдэхээр байна.

А.1.2. Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн тайланг бодитой тайлагнаагүй байна

1.7. Тус газар нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө” боловсруулах загварын дагуу 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулжээ.

1.8. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Эрүүл, аюулгүй, эко, цэвэр орчин бүрдүүлэх замаар иргэдийн нийтлэг эрх ашгийг хангасан үйлчилгээг үзүүлэгч мэргэшсэн үйлчилгээний байгууллага болох” гэсэн стратеги төлөвлөгөөний 8 зорилгын хүрээнд 23 зорилт, 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.9. Гэвч бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор төлөвлөгөөнд тусгасан хамааралгүй 1 зорилт, 8 арга хэмжээг хасаж, шинэчилж төлөвлөөгүй байна.

1.10. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг 99.8 хувийн биелэлттэйгээр тайлагнасан ч ногоон хөгжлийн бодлогоор хог дахин боловсруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлж бордооны

үйлдвэр байгуулах, “Ногоон Дархан 2032” хөтөлбөрийн хүрээнд бараат хогийн цэгийн талбайд алсын удирдлагатай ухаалаг хяналтын системтэй болох гэсэн 3 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнээс харахад төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэн зөв, бодитой тайлагнаагүй байна гэж дүгнэлээ.

A.1.3. Аж ахуйн тооцоонд шилжих үйл ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагджээ

1.11. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор “Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар”-ыг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ, “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ болгон салгаж, байгууллагын дүрмийг баталж, даргыг томилсон байна.

1.12. Ингэснээр тус газрыг орон нутгийн төсвөөс дэмжлэг авах, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан үйл ажиллагаагаа явуулах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгосон байна.

1.13. Аж ахуйн тооцоонд шилжих үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

A.2. Байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт хангалтгүй байна

A.2.1. Байгууллагын дотоод хяналт хангалтгүй байна

1.14. Дархан сумын ИТХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсан “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.1¹-т заасны дагуу газрын даргын А/11 дүгээр тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталсан байна.

1.15. Тус хяналт шалгалтын комисс нь 2022 онд нийт 8 удаагийн хяналт шалгалт хийх төлөвлөгөө боловсруулж, даргаар батлуулжээ.

1.16. Аудитаар хяналт, шалгалтын комиссын 2022 оны ажлын гүйцэтгэлтэй танилцахад хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүн, илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэж тайлагнаагүй, мэдээллийн сан бүрдүүлээгүй, шалгалтын тайлан мэдээ байхгүй, архивын нэгж болгоогүй байгаа нь хяналт шалгалтыг журмын дагуу хэрэгжүүлээгүй байна. Энэ нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.6², 4.1.7³, 4.1.9⁴-д заасантай нийцэхгүй байна.

¹ Газар нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналтын хэсэгтэй байна. Дотоод хяналтын журмыг дарга батална

² Дотоод хяналтын ажлын хэсэг нь хяналт шалгалтын ажлын үр дүн, авсан арга хэмжээнийхээ талаар жилд хоёроос доошгүй удаа дарга болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ.

³ Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх.

⁴ Дотоод хяналт шалгалтын талаар зохион байгуулсан ажил, түүний үр дүнгийн тухай тайлан мэдээг тухай бүр гаргах.

1.17. Иймд дотоод хяналт шалгалтын талаар эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа шинжилгээнд үндэслэн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулах, баримт материалыг архивын нэгж болгон тайлагнах зэрэг ажлын гүйцэтгэлд удирдлагын зүгээс онцгой анхаарч ажиллах нь зүйтэй байна.

1.18. Харин байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ерөнхий инженерийн үзлэг шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан улирал тутам хяналт тавьж ажилласан байна.

1.19. Мөн ХАБЭА-н ажилтны 2022 онд хийх ажлын төлөвлөгөө, ажлын тайлангаас харахад ажлын байрны тодорхойлолтод заасан хяналтын чиг үүргээ хангалттай хэмжээнд гүйцэтгэж, өдөр тутмын зааварчилгаа, хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ.

1.20. Байгууллагын бүтэц өөрчлөгдөж, ажилчдын шилжилт хөдөлгөөн их байгаагаас урьд ажиллаж байсан албан хаагчдын ажлын тайлан мэдээ цахимаар болон цаасаар байхгүй байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

А.2.2. Хөндлөнгийн хяналт шалгалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан байна

1.21. “ЦЭСБ аудит” ХХК 2022 оны санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийж, 29,080,326.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 29,075,088.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, 167.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 5,071.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 222 тоот албан бичгээр хүргүүлснийг хянан үзэхэд хэрэгжүүлж ажилласан байна.

1.22. Мөн тус газрын 2021, 2022 оны эхний 8 сарын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийж, 32,848.1 мянган төгрөгийн зөрчилд 3,765.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 28,882.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллажээ.

1.23. Түүнчлэн Дархан сумын Засаг даргаар батлуулсан хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Дархан сумын ЗДТГ-ын санхүүгийн албанаас тус байгууллагад төрөөс олгож буй санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.

ХОЁР. ТӨЛӨВЛӨСӨН ОРЛОГО 16.3 ХУВИАР ТАСАРЧ, ЗАРДЛЫГ 192,505.0 МЯНГАН ТӨГРӨГӨӨР ХЭМНЭСЭН БАЙНА

Б.1. Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна

Б.1.1. Хог тээврийн үйлчилгээний хураамжийн хэмжээг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулсан боловч 2022 оны аж ахуйн нэгжийн хураамжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна

2.1. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2⁵ дахь хэсэгт заасны дагуу Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 10/04 дугаар тогтоолоор “Дархан сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ”-г тогтоожээ.

2.2. Харин 2022 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

2.3. Дархан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тус сумын 2022 оны төсвийг батлахдаа хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 690,000.0 мянган төгрөгөөр баталжээ.

2.4. Аудитаар Дархан сумын ИТХ, ЗДТГ болон “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-аас хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөтэй холбоотой баримт материал олдоогүйгээс орлогын төлөвлөлтийн тооцооллыг хянаагүй болно.

2.5. Дархан сумын ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12 дугаар тогтоолоор төсөвт зохицуулалт хийхдээ хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан тус орлогыг 372,267.7 мянган төгрөгөөр өсгөж, 1,062,267.7 мянган төгрөгөөр баталжээ.

2.6. Төлөвлөгөөний тооцооллыг хянан үзэхэд айл өрхийн хураамжийн хэмжээг баг тус бүрээр тооцсон боловч аж ахуйн нэгжийн хураамжийн хэмжээг бодитой тооцоогүй байна. Энэ нь 2022 оны эхний хагас жилд гэрээ хийж төлбөрөө баталгаажуулсан аж ахуйн нэгжийн тоо цөөн, цахим бүртгэл болон дата тоон мэдээлэл байхгүйгээс шалтгаалжээ.

2.7. Харин 2022 оны 08 сараас борлуулалтын программ нэвтрүүлж, 2022 оны эцэст 866 аж ахуйн нэгжтэй тогтмол төлбөр төлөхөөр, 164 аж ахуйн нэгжтэй дуудлагаар хогоо ачуулахаар гэрээ хийсэн байна.

2.8. Мөн 2023 оны төсвийг хянан үзэхэд орлогын төлөвлөгөөг айл өрх, аж ахуйн нэгж бүрээр тооцооллыг гаргасан байв.

⁵ Хог хаягдлын талаар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 9.1.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.2.1. энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах; 9.2.2. энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох

Б.1.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж тооцсон хугацаанд хэрэгжээгүйгээс орлогын төлөвлөгөө 16.3 хувиар тасарсан байна

2.9. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12⁶ дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 41.8⁷ дахь хэсэгт заасны дагуу тус байгууллагын аж ахуйн нэгж, айл өрхүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого Дархан сумын төсвийн орлогын дансанд төвлөрч байна.

2.10. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2022 онд 1,062,267.7 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 889,587.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 172,679.8 мянган төгрөгөөр буюу 16.3 хувиар тасарчээ.

2.11. Орлого тасарсан шалтгааныг судлан үзэхэд шинэчлэн тогтоосон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 2022 оны 7 дугаар сарын эхнээс мөрдөхөөр тооцоолсон ч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр бүртгэсэн тул шинэ тарифыг тайлант оны 9 дүгээр сараас хэрэгжүүлэн ажилласан нь төлөвлөгөө биелэгдэхгүйд нөлөөлжээ.

2.12. Аудитаар орлогын гүйлгээг Дархан сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай тулган шалгахад зөрүү илрээгүй болно.

Б.2. Тайлант онд дунджаар 50 орон тоо дутуугаас зардлыг 192,505.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна

Б.2.1. Үйл ажиллагааны зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна

2.13. Байгууллагын үйл ажиллагаа, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Дархан сумын төсвөөс дэмжлэг байдлаар олгож байна.

2.14. “Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар”-ын 2022 оны төсвийн төсөлд нийт зардлыг 4,648,732.5 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөснийг 787,271.4 мянган төгрөгөөр бууруулж, 3,861,461.1 мянган төгрөгөөр баталжээ.

2.15. Тайлант хугацаанд тус газар нь 2 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон салснаар “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ 2022 оны бизнес төлөвлөгөөг боловсруулж, Дархан сумын Засаг даргаар батлуулсан байна.

2.16. “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2022 оны зардлын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад 192,505.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

⁶ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.12 хог хаягдлын үйлчилгээний хураамж

⁷ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсвөт төвлөрүүлнэ

Хүснэгт 1. 2022 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа

(мянган төгрөгөөр)

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	2,838,587.1	2,646,082.1	(192,505.0)
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,574,732.0	1,303,749.0	(270,983.0)
2	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	211,033.7	165,469.1	(45,564.6)
3	Байр ашиглалттай холбоотой зардал	291,185.3	247,817.3	(43,368.0)
4	Хангамж бараа материалын зардал	438,293.0	430,452.3	(7,840.7)
5	Урсгал засварын зардал	97,354.0	267,352.6	169,998.6
6	Нормативт зардал	66,513.8	56,157.8	(10,356.0)
7	БГАҮ-ний төлбөр	53,823.7	76,714.1	22,890.4
8	Бараа, үйлчилгээний бусад зардал	20,320.0	13,348.3	(6,971.7)
9	Бусад урсгал шилжүүлэг	85,331.6	85,021.6	(310.0)

2.17. Зардлын гүйцэтгэл 2,646,082.1 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь ажилчдын орон тоо дутуугаас цалин, НДШ 316,547.6 мянга, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд бусад зардлыг 68,846.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.


2.18. Гэвч бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, автомашины тоо нэмэгдсэн, эвдрэл гэмтэл их гарсан шалтгаанаар урсгал засварын зардлыг 169,998.6 мянган төгрөгөөр, төлөвлөгөөнд тусгагдаагүй борлуулалтын программ нэвтрүүлснээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 22,890.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлжээ.

Б.2.2. Байгууллагын анхан шатны баримтын бүрдэл хангалттай боловч хууль, журамд нийцээгүй 32,607.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна

2.19. Тайлант онд нийт зардлын 55.5 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд, 9.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 16.3 хувийг хангамж бараа материалын зардалд, 10.1 хувийг урсгал засварын зардалд, 2.1 хувийг нормативт зардалд, 2.9 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 0.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 3.2 хувийг бусад урсгал шилжүүлгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Дүрслэл 1. Зардлын ангиллын эзлэх хэмжээ

(хувиар)



2.20. Аудитаар харилцах дансны зарлагын 561 гүйлгээнээс МҮЕА-ын 2018 оны А/151 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу 90 хувийн баталгааны түвшинд 2.5 хувийн алдааны хязгаарт түүврийн хэмжээг тооцоолон 370 гүйлгээг шалгалаа. Тооцоолсон түүврээс 10.0 сая төгрөгөөс дээш 68 гүйлгээг дангаараа нөлөө бүхий зүйлс гэж авч үзэн, үлдсэн 302 гүйлгээг random программаар сонгов.

2.21. Зардлын гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг 3,614.8 мянган төгрөгөөр илүү олгосон.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, авто тээврийн хэрэгслийн торгуулийн төлбөрт 844.6 мянга, бэлэг дурсгалын зүйлд 235.0 мянга, хүнсний зүйлд 437.8 мянган төгрөгийг зарцуулсан.
- Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөл болох цахилгаан шатуудын аюулгүй ажиллагаа, ашиглалтын хэвийн үйл ажиллагаанд зориулж 27,475.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

2.22. Дээрх зөрчлүүдэд 5,132.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 27,475.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

2.23. “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь тайлант онд орон нутгийн төсөвт 889,587.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 2,688,641.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

2.24. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.25. Иймд цаашид орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах нөөц боломжийг судлан, үе шаттайгаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжих шаардлагатай байна.

2.26. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба тус газрын 2021, 2022 оны 8 дугаар сарын санхүүгийн баримт материалыг шалгаад цалин хөлс, шатахуунтай холбоотой төлбөрийн акт тогтоосон, мөн санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардалд төлбөрийн акт тогтоосон тул уг 2 зардлыг аудитад хамруулаагүй болно.

ГУРАВ. ТУС БАЙГУУЛЛАГА ХӨРӨНГИЙГ БҮРЭН АШИГЛАЖ БАЙНА

В.1. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулаагүй байна

В.1.1. Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулсан байна

3.1. “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь 2022 онд нээлттэй тендер шалгаруулалтаар 1, харьцуулалтын аргаар 2, нийт 3 худалдан авах ажиллагааг төлөвлөж, үнэлгээний хороог 5 - 7 гишүүнтэйгээр байгуулжээ.

3.2. Үнэлгээний хорооны гишүүд нь тендерийн баримт бичиг боловсруулахдаа Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн агуулга, гэрээний ерөнхий нөхцөл хэсгүүдийг хэвээр үлдээн, тендерт оролцогчид өгөх зааварчилгаа, гэрээний тусгай нөхцөл, тусгай зөвшөөрөл, урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, захиалагчаар батлуулсан байна.

3.3. Төрийн худалдан авах цахим системээр тендерийн урилгыг өдөр тутмын “Өглөөний сонин” болон www.tender.gov.mn сайтад давхардсан тоогоор 4 удаа байршуулж, ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг бүрдүүлжээ.

3.4. Харин үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулаагүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4⁸ дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

3.5. Мөн тендерийн холбогдох баримт бичгийг архивлахдаа худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг тусгай тээгч (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгалаагүй нь Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох, мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.3⁹-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

В.1.2. Тайлант хугацаанд 11,577.4 мянган төгрөгийн GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигч худалдан авснаар шатахууны зардлыг 3,429.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна

3.6. Тайлант онд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор худалдан авах барааг жил бүр төсөвлөн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллажээ.

3.7. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тээврийн хэрэгслийн шатахуун, тос, тосолгооны материалын 420,000.0 мянга, улирлын чанартай ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд шаардлагатай бараа материалын 35,000.0

⁸ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна


⁹ Захиалагч журмын 8.2-т зааснаар холбогдох баримт бичгийг архивлахдаа хуулийн 49.2.3, 49.2.5-д заасан материалыг цахим хэлбэрээр тусгай тээгч(зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгална

мянга, автомашины дугуй, олгой хаймар, сэлбэг хэрэгслийн 30,000.0 мянган төгрөгийн урсгал засварын материалыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2¹⁰, 33 дугаар зүйлийн 33.2¹¹ дахь хэсэгт заасны дагуу нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтаар тус тус зохион байгуулж, худалдан авалт хийжээ.

3.8. Харин шууд худалдан авалтаар 32 нэр төрлийн 32,331.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, тухай бүр худалдан авалт хийсэн байна.

3.9. Дээрх тоног төхөөрөмжүүдээс онцлоход GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигчийг тээврийн хэрэгсэлд суурилуулсан нь байгууллагын түлшний зардал хэмнэгдсэн хог тээвэрлэлтийн хяналт сайжирсан зэрэг үр дүнтэй хэрэгцээнд нийцсэн худалдан авалт болжээ.

Зураг 1. GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигч



В.2. ОНХО, ОНХС-аар бий болсон хөрөнгүүдийг бүрэн ашиглаж байна

В.2.1. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь байгууллагын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна

3.10. Тус газар 2022 оны санхүүгийн тайлангаар ОНХС болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 96 нэр төрлийн 6,811,123.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнажээ.

Дүрслэл 2. Шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалт



¹⁰ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ

¹¹ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно

3.11. Аудитаар шинээр нэмэгдсэн хөрөнгүүдийг тогтоол, шийдвэртэй тулган шалгахад аймгийн ИТХ-ын 2022 оны 66 дугаар тогтоолын дагуу 21,600.0 мянган төгрөгийн нарс мод, 49,000.0 мянган төгрөгийн гацуур модыг үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.12. Дээрх хөрөнгүүдээс тулган баталгаажуулалт хийхэд балансаас балансад шилжүүлэн авсан 18,000.0 мянган төгрөгийн 3 автомашин, ОНХС-ийн хөрөнгөөр 527,324.2 мянган төгрөгийн 4 автомашин, 430,460.0 мянган төгрөгийн 2 барилга, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 992,578.0 мянган төгрөгийн 7 автомашин нь хэрэгцээ шаардлагад нийцсэн байнгын ашиглалттай хөрөнгүүд байна.

Зураг 2. Хөрөнгө оруулалтаар бий болсон зарим хөрөнгүүд



В.2.2. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалт хангалттай сайн байна

3.13. Тайлант онд үндсэн хөрөнгийн үлдэгдэл 18,775,838.3 мянган төгрөг болж 37,926,859.3 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2023 оны А/02 дугаар тушаал, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар тогтоолоор “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-т 30,540,830.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.14. Мөн өөрийн хөрөнгөөр 32,331.8 мянга, үнэ төлбөргүйгээр буюу ОНХС, ОНХО-аар 6,811,123.8 мянган төгрөгийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нэмэгдэж, хэвийн ажиллагаатай хөрөнгийг 9,150.0 мянган төгрөгөөр дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгасан байна.

3.15. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 9 дүгээр тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авар арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд улсын үзлэг, тооллого зохион байгуулж, аймгийн ИТХ-ын 2022 оны 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/344 дүгээр захирамжийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 71 нэр төрлийн 365,591.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, нийтийн эзэмшлийн хөрөнгө, ногоон байгууламж зэргийг акталсан байна.

В.2.3. “Хуванцар үрэл боловсруулах үйлдвэр” тэтгэлэгт оролцон, 45,000.0 мянган төгрөгийн 3 тоног төхөөрөмжийн санхүүжилт авсан боловч хэрэгжээгүй байна

3.16. Тайлант онд Азийн хөгжлийн банкны захиран зарцуулах эрх бүхий “Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон дайлан бүс нутгийг цогцлоох Япон сан”гийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Аймгуудын төвийн хатуу хог хаягдлын менежментийн төсөл”-ийн хүрээнд “Гурван бүрэн” ХХК “Дархан-Уул аймгийн төвд дахивар хүлээн авах цэг”-ийн барилга, байгууламжийг 5 цэгт байршлын дагуу суурилуулжээ.

Зураг 3. Дахин боловсруулах хог хаягдал хүлээн авах цэг



3.17. Төслийн хүрээнд тус газар “Хуванцар үрэл боловсруулах үйлдвэр” тэтгэлэгт оролцон 3 тоног төхөөрөмжийн 45,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

3.18. Гэвч тайлант онд хил, гааль хаалттай шалтгаанаар тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийгээгүй, цахилгааны асуудал шийдэгдээгүй учир төсөл хэрэгжээгүй байна.

3.19. Харин байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор аймгийн Засаг даргад ажлын багаж, хэрэгсэл нийлүүлэх 34,000.0 мянган төгрөгийн төсөл хүргүүлснээс 20,000.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл худалдан авах төслийг шийдвэрлэсэн байна.

Холбогдох байгууллагын санал, тайлбар:

*С.Батцэцэг-а.
Аудитын байсанг тусгаар
заалгажүүлс.*



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ОНӨААТҮГ

4 дүгээр баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, 45065
Утас/Факс: (976) 7037-0121
Цахим шуудан: darkhan.hot.tohijilt@gmail.com

2023 07 05 № 264

талай _____ -ны № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР-Т

Тус байгууллагат хийсэн 2022 оны
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцсан.

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА


ХТҮАЭН15 4263263
1922050018

З.ЭРДЭНЭБАТ

D/Word/Alban toot

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчлээгүй байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэн зөв, бодитой тайлагнаагүй байна.
- Аж ахуйн тооцоонд шилжих үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
- Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан үүсгээгүй, хяналт шалгалтын ажлын баримт материалыг архивын нэгж болгох, баримтжуулах ажлыг хийгээгүй байна.
- Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг заасан хугацаанд арилгаж, хэрэгжүүлж ажилласан байна.
- Орлогын төлөвлөгөөг 83.7 хувиар биелүүлж, зардлыг 192,505.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.
- Хууль, журамд нийцээгүй 32,607.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна.
- Төвлөрүүлсэн орлогоос 3 дахин их санхүүгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс авсан байна.
- Үнэлгээний хороонд мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцуулаагүй, тендерийн баримт бичгийг тусгай тээгч дээр архивлан хадгалаагүй байна.
- GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигчийг тээврийн хэрэгсэлд суурилуулснаар түлшний зардлыг хэмнэж, хог тээвэрлэлтийн хяналт сайжирсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

*“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга
З.Эрдэнэбатад зөвлөж байна:*

1. “Дотоод хяналт, шалгалтын үр нөлөөг сайжруулж, илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулж, ажлын баримт материалыг архивын нэгж болгох
2. Албан хаагчдын ажлын тайлан, мэдээ цахимаар болон цаасаар байхгүй байгаа тул “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах
3. Орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах нөөц боломжийг судлан, үе шаттайгаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжих
4. Үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оруулах
5. Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулах, холбогдох, мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.3 дахь заалтыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор багтаан Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023.07.05

Аудитаар тогтоосон төлбөрийн акт:



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 05 дугаар сарын 22

Дугаар 05/01

Дархан сум

10960287/2023-2023/36 - ШТА-ГА

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагад ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Оюунбилэгийг өндөр насны тэтгэвэрт гарахад 3,614,762.00 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын 2.1-т “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү олгосон 3,614,762.00 (Гурван сая зургаан зуун арван дөрвөн мянга долоон зуун жаран хоёр) төгрөгийг ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Оюунбилэгээр төлүүлж, Төрийн сан дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ



009050290



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 66/02

Дархан сум

20960231/ЗПА - 2023/36 - КПА-ТА

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага тайлант онд авто тээврийн хэрэгслийн торгуулийн төлбөрт 844,600.00, бэлэг дурсгалын зүйлд 235,000.00, хүнсний зүйлд 437,811.00 төгрөгийг тус тус зарцуулжээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-т “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,517,411.00 (Нэг сая таван зуун арван долоон мянга дөрвөн зуун арван нэг) төгрөгийг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхцэцэг нараар хувь тэнцүүлэн төлүүлж, Төрийн сан дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ



009050293

Аудитаар хүргүүлсэн албан шаардлага:



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 53/07

Дархан сум

10960287/27A-2023/36-УГА-1A

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөл болох цахилгаан шатууд бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийн аюулгүй ажиллагаа, ашиглалтын хэвийн үйл ажиллагаанд зориулж 2022 онд 27,475.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д “Холбоо нь дундын өмчлөлийн эд хөрөнгө, шугам сүлжээний засвар, үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд засвар, үйлчилгээ хийлгэх мэргэжлийн байгууллагаа чөлөөтэй сонгох эрхтэй”, 16 дугаар зүйлийн 16.6-д “Орон сууцны байшингийн ашиглалтын хугацаанд дундын өмчлөлийн эд хөрөнгөд хамаарах дээвэр, цахилгаан шат зэрэгт их засвар хийх үед их хэмжээний хөрөнгө шаардагдах бол барилгын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс нэг удаа санхүүжүүлж болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн цахилгаан шатуудыг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор холбогдох сууц өмчлөгчдийн холбоонд хүлээлгэн өгч, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,

- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

009040161





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар

54/02/A0970285/ДАА-2023/36-ШТА-ГА

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны 66 дугаар тогтоолын дагуу 21,600.0 мянган төгрөгийн нарс мод, 49,000.0 мянган төгрөгийн гацуур модыг үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Үндсэн хөрөнгөнд бүртгээгүй нийт 70,600,000 /далан сая зургаан зуун мянга/ төгрөгийн модыг үндсэн хөрөнгөөр бүртгэж биелэлтийг 2023 оны 08 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын дарга З.Эрдэнэбат, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Г.БАТМЯГМАР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

009040166